



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн "Дархан орон нутгийн зам тээвэр" ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/3/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:
Утас: 70378845
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Т.Эрдэнэтуяа
Утас: 95112689
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ДАРХАН ОРОН НУТГИЙН ЗАМ
ТЭЭВЭР” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Д.АМГАЛАНБАЯР ТАНАА

2024.03.15 № 156

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01А/491 тоот захирамжаар 29,400.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 2024 оны 01А/524 тоот захирамжаар 5,000.0 мянган төгрөгийн авто зам, Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор 4,950,928.0 мянган төгрөгийн авто зам, Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор 497,251.6 мянган төгрөгийн авто замыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан тушаалын цалин, хөлсний доод нийтлэг жишгийг батлах тухай” 52 дугаар тогтоолыг үндэслэн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 408,372.7 мянган төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 81.2 хувиар өссөн байна.

Бусад асуудал

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	23,101,216.90	4,688,325.23
1.1.2	Дансны авлага	1,662,627.53	7,359,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.6	Бараа материал	105,376,357.11	133,525,531.59
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо/	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	130,140,201.54	145,572,856.82
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	73,386,121,273.80	72,117,578,253.50
1.2.2	Биет бус хөрөнгө	2,652,995.77	2,484,350.80
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	73,388,774,269.57	72,120,062,604.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	73,518,914,471.11	72,265,635,461.12
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.3	Татварын өр	4,801,238.36	11,145,979.53
2.1.1.4	НДШ-ийн өр	1,946,758.78	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.9	Богино хугацаат бусад өр төлбөр	116,383.49	220,203.51
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,864,380.63	11,366,183.04
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	6,864,380.63	11,366,183.04
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	22,471,303,981.29	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	14,905,686,103.25	14,905,686,103.25
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	65,471,839,960.50	93,452,733,867.90
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(29,336,779,954.56)	(36,104,150,693.07)
2.3.11	Эздийн өмчийн дүн	73,512,050,090.48	72,254,269,278.08
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	73,518,914,471.11	72,265,635,461.12

ХТ05430 @ 9022999

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Д/д	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	581,636,302.21	611,945,727.27
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	581,636,302.21	611,945,727.27
4	Түрээсийн орлого		
8	Бусад орлого		164,058,802.06
9	Борлуулалт маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,884,269,515.01	6,594,032,169.74
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	385,695,281.17	949,343,098.10
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(6,688,328,493.97)	(6,767,370,738.51)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(6,688,328,493.97)	(6,767,370,738.51)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	(6,688,328,493.97)	(6,767,370,738.51)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(6,688,328,493.97)	(6,767,370,738.51)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		




2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	62,736,523,962.50	(22,648,451,460.59)	55,039,586,572.78
Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	62,736,523,962.50	(22,648,451,460.59)	77,465,062,586.45
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,688,328,493.97)	(6,688,328,493.97)
Өмчид гарсан өөрчлөлт			2,735,315,998.00		2,735,315,998.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	65,471,839,960.50	(29,336,779,954.56)	73,512,050,090.48
Няглан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	22,471,303,981.29	14,905,686,103.25	65,471,839,960.50	(29,336,779,954.56)	73,512,050,090.48
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,767,370,738.51)	(6,767,370,738.51)
Өмчид гарсан өөрчлөлт	(22,471,303,981.29)		27,980,893,907.40		5,509,589,926.11
Бусад дэлгэрэнгүй орлого					-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	14,905,686,103.25	93,452,733,867.90	(36,104,150,693.07)	72,254,269,278.08



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	845,372,493.98	1,260,398,723.39
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	580,311,661.30	760,084,247.01
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	265,060,832.68	500,314,476.38
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	831,432,842.58	1,268,958,328.15
	Ажиллагчдад төлсөн	182,861,846.00	330,175,622.35
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	49,331,079.63	96,470,062.59
	Бараа материал худалдан авахад төлсөн	496,376,499.34	704,599,600.71
	Ашиглалтын зардалд төлсөн	2,591,564.96	5,006,010.03
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	83,927,057.98	92,395,543.27
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	16,344,794.67	40,311,489.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,939,651.40	(8,559,604.76)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(5,262,454.54)	9,853,286.91
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(5,262,454.54)	9,853,286.91
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,262,454.54)	(9,853,286.91)
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,677,196.86	(18,412,891.67)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,424,020.04	23,101,216.90
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	23,101,216.90	4,688,325.23



2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
2	Нийт орлого	м/тег	581,636.30	826,602.80	776,004.50	(50,598.30)	93.9%
	Үүнээс: Өөрийн орлого	м/тег	581,636.30	826,602.80	776,004.50	(50,598.30)	93.9%
3	Нийт зардал	м/тег	7,269,964.80	826,602.80	7,543,375.20	6,716,772.40	89.04%
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	м/тег					
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	м/тег	7,269,964.80	826,602.80	7,543,375.20	6,716,772.40	89.04%
	в) Хөрөнгө оруулалт их засвар	м/тег					
4	Цэвэр ашиг, алдагдал	м/тег	(6,688,328.50)	-	(6,767,370.70)	(6,767,370.70)	89.04%

ХТ05430691228399

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын зорилго нь зам ашиглалтын аюулгүй байдлыг ханган орон нутгийн автозам, замын байгууламжийн засвар арчлалтын ажил, авто замын мэдээллийн санг бүрдүүлэх, холбогдох судалгааг хийх, шинээр хийгдсэн авто замыг бүртгэлжүүлэх, Авто замын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Орон нутгийн авто замын сангийн орлогыг бүрдүүлэх
- Орон нутгийн автозам, замын байгууламжийн засвар арчлалтын ажил, авто замын мэдээллийн санг бүрдүүлэх
- Авто замын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Тус байгууллагын захирал зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,253,279.0 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	23,101.2	4,688.3	(18,412.9)
Дансны авлага	1,662.6	7,359.0	5,696.4
Бараа материал	105,376.4	133,525.5	28,149.2
Үндсэн хөрөнгө	73,386,121.3	72,117,578.3	(1,268,543.0)
Биет бус хөрөнгө	2,653.0	2,484.4	(168.6)
Нийт хөрөнгө	73,518,914.5	72,265,635.5	(1,253,279.0)
Богино хугацаат өр төлбөр	6,864.4	11,366.2	4,501.8
Эздийн өмчийн дүн	73,512,050.1	72,254,269.3	(1,257,780.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	73,518,914.5	72,265,635.5	(1,253,279.0)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 4,688.3 мянган төгрөг болж өмнөх оноос 18,412.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,260,398.7 мянган төгрөгийн орлого олж, 1,278,811.6 мянган төгрөгийг зарцуулсантай байна.

Дансны авлагын үлдэгдэл 7,359.0 мянган төгрөг болж өмнөх оноос 5,696.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй нэгж, байгууллагаас авах авлага 6,936.0 мянган төгрөгөөр, ажилчдаас авах авлага 423.0 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Бараа материалын үлдэгдэл 133,525.5 мянган төгрөгөөр 28,149.2 мянган төгрөгөөр өссөн нь 277,546.3 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, Дархан-Уул аймгийн Иргэдийн хурлын 2024 оны 13 дугаар тогтоолоор 27,010.3 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч данс бүртгэлт бүртгэж, 276,407.4 мянган төгрөгийн зардлыг тайлагнасан нь шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 72,120,062.6 мянган төгрөг болж 1,268,711.7 мянган төгрөгөөр буурсан нь 6,454.1 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 3,399.2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил буюу нийт 9,853.3 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн орлогоор худалдан авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01А/491 тоот захирамжаар 29,400.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, 2024 оны 01А/524 тоот захирамжаар 5,000.0 мянган төгрөгийн авто зам, Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2024 оны 13 дугаар тогтоолоор 4,950,928.0 мянган төгрөгийн авто зам, Шарын гол сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар тогтоолоор 497,251.6 мянган төгрөгийн авто замыг тус тус үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024

оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01-A/522 тоот захирамжаар 2,702,915.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан болон тайлант онд 5,811,941.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,366.2 мянган төгрөг болж өмнөх оноос 4,501.8 мянган төгрөгөөр өссөн нь Дархан ус суваг ХК-ийн 6,939.0 мянган төгрөгийн гэрээт ажлын өр төлбөр нөлөөлсөн байна.

Өмчийн дүн 72,254,269.3 мянган төгрөг болж 1,257,780.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн 6,767,370.7 мянган төгрөгийн алдагдал нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын төлөвлөгөөг боловсруулж, Дархан-Уул аймгийн ИТХ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор 2024 оны төсвийг 627,510.0 мянган төгрөгөөр баталж, 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор 826,602.8 мянган төгрөг болгон нэмэгдүүлэн тодотгол хийсэн байна.

Тайлант оны гүйцэтгэлээр 776,004.5 мянган төгрөгийн орлого, 7,543,375.2 мянган төгрөгийн зардлыг тайлагнаж, 6,767,370.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогыг 826,602.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 776,004.5 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 93.9 хувийн гүцэтгэлтэй байна.

Тайлант онд 6,767,370.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь тухайн тайлант оны үндсэн хөрөнгийн 5,811,941.5 мянган төгрөгийн элэгдлийн зардал, 949,343.1 мянган төгрөгийн хөрөнгийг акталсаны гарз зэрэгтэй холбоотой байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Ч.Цэрэннадмид, чанарын менежер Т.Эрдэнэтуяа, дараагийн шатны хяналтыг

ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ-ийн 2024 оны санхүүгийн тайланг тайланг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 7,269,964.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 72,699.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн захирагч нь байгууллагын хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж, хэмнэлтийн горимыг баримтлан, ажиллаж байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал 157 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүнд, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд

Өмнөх аудитаар нийт 3,822.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 830.1 мянган төгрөгийн акт, 2,992.5 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	830.1	1	830.1	100.0
Зөвлөмж	1	2,992.5	1	2,992.5	100.0
Нийт дүн	2	3,822.6	2	3,822.6	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,471,303.9 мянган төгрөгийн алдаа¹ илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

- Тус “Дархан орон нутгийн зам тээвэр” ОНӨААТҮГ -ын эхлэлтийн балансад эздийн өмчийн дүн байгаагүй бөгөөд төрийн өмчийг 22,471,303.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйл “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт” 21^{1.7}. “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана.” заалт, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, санхүүгийн тайлангийн аудитын “Ангилал”, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул эздийн өмчийн бусад хэсгээр бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 1,345.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Илрүүлэлт: Тус байгууллагын 5 албан хаагчид цалин, ээлжийн амралтыг 942.9 мянган төгрөгөөр давхардуулан олгосон нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 2.8 дахь заалтад “Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд:1 ажилтанд ажилласан хугацаанд олгоно.” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Илрүүлэлт: Тус байгууллагын менежер К.Болорчимэгт үндсэн баримтгүйгээр илүү цагийн хөлсийг 402.6 мянган төгрөгөөр илүү бодож олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109.1-т “Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.” гэж заасантай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

- Албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй болно.

5.3 Зөвлөмж²

Аудитаар зөвлөмж илрээгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² 20.5.Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулааг үй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тус ОНӨААТҮГ нь эхлэлтийн балансд эздийн өмчийн дүн байгаагүй бөгөөд төрийн өмчийг 22,471,303.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	1	22,471,303.9			1	22,471,303.9							
Дүн	1	22,471,303.9			1	22,471,303.9							

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс										Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн
Тус байгууллагын 5 албан хаагчид цалин, ээлжийн амралтыг 942.9 мянган төгрөгөөр давхардуулан олгосон байна.	1	942.9	1	942.9									
Тус байгууллагын менежер К.Болорчимэгт үндсэн баримтгүйгээр илүү цагийн хөлсийг 402.6 мянган төгрөгөөр илүү бодож олгосон байна.	1	402.6	1	402.6									
Дүн	2	1,345.5	2	1,345.5									

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-